

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дугаар зүйл, Мандал даатгал хувьцаат компанийн дүрмийн 8.14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. Мандал даатгал ХК нь 2019 онд ашигтай ажилласныг үндэслэн 2019 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 4 /дөрвөн/ төгрөг буюу нийт 2,497,206,400.00 /хоёр тэрбум дөрвөн зуун ерэн долоон сая хоёр зуун зургаан мянга дөрвөн зуун/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгохоор тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу хуваарилах ногдол ашгийг 2020 оны 6 сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар олгосугай.
4. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилсаны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх бөгөөд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа болохыг дурдсугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах ажлыг гүйцэтгэх захирал Б.Жавхланд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ